



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Ахмадын сан байгуулах тухай

Монгол Улсын “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад тэтгэмж олгох, түлээ нүүрс авах, ажил үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын цалингийн нийт сангийн 1 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмад сан” байгуулсугай.

2. “Ахмад сан”-ийн тайлан, тооцоог улирал тутам гаргаж, захиргааны зөвлөлд мэдээлж байхыг эд хариуцагч /Дашдуламын Энхмаа/-д хариуцуулсугай.

ЗАХИРАЛ



Б.БАЙГАЛМАА